

Азийн олон улсын хүүхдийн кино наадам (урилгат хөтөлбөр) тайлан
(Оролцсон улс: Монгол улс/ сэдэв: Азийн олон улсын хүүхдийн кино наадам тайлан)

1. Хөтөлбөрийн агуулга

Япон орны тухай ойлголтыг гүнзгийрүүлэн дэмжих зорилготой “JENESYS2018” хөтөлбөрөөр Монгол улсаас ахлах сургуулийн багш, сурагчдаас бүрдсэн 10 хүний бүрэлдэхүүнийг 2018 оны 11 сарын 20-ны өдрөөс (Мя) 11 сарын 28 өдөр (Лха) хүртэл 8 шөнө 9 өдрийн хугацаагаар японд урьж ирүүлэн, сургуулиудаар айлчилж, японы ахлах сургуулийн сурагчид болон хотын ард иргэдтэй найрсаг нөхөрлөлөө бататгаснаас гадна, японы улс төр, эдийн засаг, нийгэм, түүх, дэвшилтэт салбар, уламжлалт үйлдвэрлэл, соёл урлагын холбогдох байгууламжуудыг үзэж танилцан, орон нутаг, хотуудад айлчилснаар, японы талаар олон талын ойлголттой болж, япон монгол хоёр улсын өсвөр насны залуучууд хоорондын нөхөрлөлийг бэхжүүлж чадлаа.

Гол арга хэмжээ болох Хоккайдогийн Китами хотод зохион байгуулагдсан “12 дахь удаагийн Азийн олон улсын хүүхдийн кино наадам”-д оролцож, японы ахлах сургуулийн сурагчид, хотын ард иргэдтэй найрсаг нөхөрлөлийн харилцаа тогтоож, япон улс болон японы соёлын талаарх мэдлэг, ойлголтоо гүнзгийрүүлж чадлаа. Кино наадамд оролцохын ялдамд, анимэгийн мэргэжлийн сургууль дээр очиж, япон улсын дэлхий дахинд алдартай анимэгийн шилдэг технологийн ертөнцтэй танилцаж японы соёл, урлагаас суралцлаа. Байгаль орчныг хамгаалах талаарх мэдлэгээ гүнзгийрүүлж, хог хаягдлын үйлдвэрийг үзэж танилцсанаар, байгаль орчныг хамгаалах арга барилыг олж мэдсэн ба усан аквариум, Окотскийн мөсөн музейг үзэж, хоккайдогийн эргэн тойрны амьтад, орон нутгийн байгалийн өвөрмөц байдлыг үзэх боломж олдсон нь байгаль орчныг хамгаалах ухамсарыг дээшлүүлэхэд тус нэмэр өглөө.

【Оролцсон улс, оролцогчдын тоо】

Монгол улс 10 хүн (9 Ахлах сургуулийн сурагчид+ 1 удирдах багш)

【Айлчилсан газар】



Токио хот, Хоккайдо

2. Айлчлалын өдрийн хуваарь

11 сарын 20 өдөр (Мя)	Нарита олон улсын нисэх онгоцны буудалд бууж японд ирнэ Чиг баримжаа олгох тайлбар танилцуулга
11 сарын 21 өдөр (Лха)	Хоккайдо руу хөдөлнө Албан ёсны айлчлал: Китами хот Хүлээн авах ёслолын ажиллагаа (Китами хотын иргэдийн ордоны бага танхимд)
11 сарын 22 өдөр (Пү)	Кино наадамд ирсэн бүтээлүүдийг үзэж танилцана 【 Кино наадамтай холбогдох】 (Китами хотын иргэдийн ордоны бага танхимд) Сургуулийн үйл ажиллагаатай танилцана (Японы улаан загалмайн Хоккайдо сувилахуйн их сургууль)
11 сарын 23 өдөр (Ба)	Хойд эх газрын аквариум (“Уулын ус” аквариум)-г үзнэ Худалдааны газраар орно: Тообү Ийст молл Мизүно дэлгүүр Танилцах уулзалт, оройн хоол (Хоккай худалдааны их сургуулийн биеийн тамирын зааланд)
11 сарын 24 өдөр (Бя)	Керлингийн спортоор танилцана Кино наадмын шалгаруулалт, шагнал гардуулах ёслолд оролцоно (Китами

- хотын иргэдийн ордоны их танхимд)
 Нөхөрсөг уулзалт: Үдэлтийн арга хэмжээ (Китами хотын ажилтан залуучуудын ордонд)
- 11 сарын 25 өдөр (Ня) Охотскийн мөсөн музейг үзнэ
 Токио руу хөдөлнө
- 11 сарын 26 өдөр (Да) Токиогийн 23 дүүргийн хог боловсруулах үйлдвэрийн эвлэл Боомтны хог боловсруулах үйлдвэрийг үзнэ
 Одайба талбайгаар явж танилцана
 Япон соёлоос суралцах: жижиг хавчаарны цех (Дайва сангүр үйлдвэрт)
 Мэйжи Жингү хийдийг үзнэ
- 11 сарын 27 өдөр (Мя) Yoyogi Animation Institute, Inc. Токио дахь сургуультай танилцана
 Эдо Токио музейг үзнэ
 Workshop
- 11 сарын 28 өдөр (Лха) Наритасан Шиншёо сүмийг үзнэ
 Эх орондоо харина
- ※Энэ жилийн кино наадмын сэдэв: “Өөрийн үүрэг, хариуцлага”

3. Хөтөлбөрийн тайланд ашиглах зураг

	
<p>11 сарын 21 өдөр 【Албан ёсны айлчлал】 Китами хот</p>	<p>11 сарын 22 өдөр 【Сургуультай танилцав】 (Японы улаан загалмайн Хоккайдо сувилахуйн их сургууль)</p>
	
<p>11 сарын 23 өдөр Хойд эх газрын аквариумыг үзэв</p>	<p>11 сарын 23 өдөр 【Танилцах уулзалтанд оролцож, оройн хоол идэв】</p>



11 сарын 24 өдөр
【Керлингийн спортоос суралцав】
Керлинг



11 сарын 24 өдөр 【 Кино наадам】
Кино наадмын шалгаруулалт, шагнал
гардуулах ёслол



11 сарын 24 өдөр 【Нөхөрсөг уулзалт】
Үдэлтийн арга хэмжээ



11 сарын 25 өдөр
Охотскийн мөсөн музейг үзэв



11 сарын 26 өдөр Токиогийн 23 дүүргийн хог
боловсруулах үйлдвэрийн эвлэлийн Боомтны хог
боловсруулах үйлдвэрийг үзэв



11 сарын 26 өдөр 【Япон соёлоос суралцав】
Дайва санпүр үйлдвэрын цех



11 сарын 27 өдөр
Yoyogi Animation Institute, Inc-г үзэв



11 сарын 27 өдөр
【Workshop】

4. Оролцогчдын сэтгэгдэл

◆Японд байх хугацаанд мэндчилгээний соёл, цэвэр орчин, аюулгүй байдал, тохилог орчин гээд их олон зүйлийг мэдэрсэн. Манай орноос ялгаатай зүйл нь гэвэл замын түгжрэл, утаа байхгүй, мөн түүнчлэн эко орчин, хүмүүс нь гүйж, дугуй унаж явдаг зэрэг зүйл юм. Надад хамгийн их таалагдсан зүйл нь хог хаягдлаа ялган хаяж, дараа нь түүгээрээ бүтээгдэхүүн хийж, дахин боловсруулдаг нь. Үүнээс гадна эрүүл мэндэд хэрэгтэй, амин дэм, эрдэс бодисоор баялаг хоол хүнс хэрэглэдэг. Бас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зам бай зэрэг байдаг нь үнэхээр их таалагдсан.

◆Би энэ аяллын вцад япон улс ямар соёлтой ямар их хүнээ хүндэтгэдэг болохыг ойлгож мэдэрч явсан. 11/20-оос 11/28-ны өдрийн турш би Ohotsuk-ийн далай, Yama no aquarium, сувилахуйн сургууль, animation-ий студи зэрэг олон сонирхолтой зүйлс үзсэний Китами хотод тоглосон “Curling” гэх тогтоом нь өвөрмөц байхын дээр монголын “мөсөн мөргөлдөөн” гэх ардын тоглоомтой төстэй байсан. Мөн япон цайн ёслол нь урьд өмнө нь харж байгаагүй учраас үнэхээр шинэлэг санагдсан. Би эх орондоо очоод хөг гэрийнхнийгээ хогоо ангилж хийлгэж чадахгүй ч гэсэн ядаж гадуур гудамжаар хог хаяхгүй байхыг уриалж чадна.

Энэ аялал үнэхээр хөгжилтэй дурсамжтай мартагдашгүй аялал байлаа.



◆Тус айлчлалын үеэр Япон улсыг их олон удаа өөрийн улстайгаа харьцуулан үзлээ. Үүнд:

- Curling-ийн спорт нь мөнхөя Монгол орны мөс мөргөлдүүлэх тоглоомтой их адил
- Харилцааны соёл нь Монголын соёлтой эрс өөр бүгд л инээж мэндлэн харилцдаг.
- Хог хаягдал гадуур хаягдахгүй байгаа нь гайхмаар
- Хогийг өндөр түвшинд боловсруулан хэрэглэдэг. Үүгээр тог цахилгаан болон цемент тоосго гаргаж авдаг. Гэвч эдгээр зүйлийг Монголд хийх нь одоогийн байдлаар боломжгүй. Үүсэх хогоо багасгах арга л одоо үед тохирно (Reduce). Тиймд өдөр болгон пластик уут авахгүйгээр байнгын уут авна. Мөн Япон улсын харилцааны соёлыг өөрийн улсад тусган өдөр бүр эелдэгмэндэлнэ .

5. Хүлээн авагч талын сэтгэгдэл

◆Маш хөгжилтэй, сэргэлэн цовоо хүүхдүүд байлаа. Ялангуяа японы хүүхдүүдийн нэгэн адил ухаалаг утасны SNS ашиглах гэх мэтээр үе тэнгийнхэнтэйгээ ижил зүйл сонирхдог юм шиг санагдсан. Урьд нь өөр орны хүүхдүүд хүлээж авч байсан боловч, энэ хүүхдүүд хүнтэй сайхан мэндэлж чаддаг, дэг журам сайтай (автобусанд шуугихгүй, хог хаяхгүй г.м) байсан тул, монгол хүмүүсийн талаар сайхан сэтгэгдэл үлдсэн.

6. Оролцогчдын гадагш түгээсэн мэдээлэл

 <p>https://www.facebook.com/baatarsuren.ochirbat.9/posts/189361548680384</p>	 <p>https://www.facebook.com/mardnu/posts/10218306525760168</p>
<p>Монгол хэлээр) JENESYS2018 хөтөлбөрийн талаарх мэдээлэл Усан аквариум, сургууль, керлинг, хог хаях үйлдвэр дээр</p>	<p>Монгол хэлээр) JENESYS2018 хөтөлбөрийн талаарх мэдээлэл Керлинг, кино наадам дээр</p>

Mardnu Delgerbat
2018年11月25日 · 🌐

Ceremony#kitami#hokkaido#aicff_m2018 Jenesys Mongol Taro

あなた、他88人 コメント2件 シェア2件

いいね! コメント シェアする

<https://www.facebook.com/mardnu/posts/10218309093904370>

Монгол хэлээр)
Азийн олон улсын кино наадмын талаарх
мэдээлэл

Batorgil EnkhboldさんはJenesys Mongol Taroさんと一緒にいます。
2018年11月26日 · 🌐

Minato-iin hog tseverleh baiguulamj

Г.И Гармаа、Bat Gerel Baatarxuu、他13人

いいね! コメント シェアする

<https://www.facebook.com/batorgil.enkhbold.9/posts/2185200938413504>

Монгол хэлээр) Токиогийн23 дүүргийн хог хаях
үйлдвэрийн эвлэлийн Боомтны хог хаях
үйлдвэрийн талаарх мэдээлэл

7. Тайлан илтгэлийн үеэрх эх орондоо харьсны дараа хийх ажлын төлөвлөгөө

① Your Action Plan

What?

хүүхэд бүр тусар уйтгалаа цагаанаар таталзан даавуун тэр ашиглана, уриалан

When & Where?

12/1 тн 12/9 нон хүүхэд хураанаар ашиглана хийн

How?

Тусар уйтгалаа ашигланаар болсон уриалан Post бичих, хүүхэд болон Post-оо SNS, Facebook дээр тавих.

② Your Action Plan

What?

Тусар уйтгалаа, уриалан, share хийн

When & Where?

12.01 - 12.7 - н хооронд

How?

дван зураглалаа хийн video хийн. SNS-д байрлуулнаар буцаа, хүүхэдүүд өөрсдийнх, хатгал share хийн

- ① グループ全員がビニール袋を使わないようにすること。自分の買い物袋を使う。
12/1～9の間でビニール袋を使わないという内容のポストを各自で作成し、グループ全員でポストをSNS、FACEBOOKで広げる。
- ② 12/1～7の間に日本で撮影した写真で動画を編集し、帰国後グループメンバーが作成し、全員でSNSにて投稿し、シェアする